

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ШУУРХАЙД ӨГСӨН ҮҮРЭГ
ДААЛГАВРЫН ДАГУУ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг: Хяналт шалгалт хийсэн үндэслэл

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн №6 дугаар шуурхай хурлаас өгсөн “2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн цаг агаарын гамшигт болон аюултай үзэгдлийн үеэр сүлжээ тасарч, радар, цахим сайт болон дотоод серверийн үйл ажиллагаа доголдсон шалтгааныг тодруулан хяналт, шалгалт хийж, дүгнэлт танилцуулах” үүрэг даалгавар, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.5-д заасны дагуу дотоод хяналт, шалгалт хийлээ.

Хоёр: Ажлын хамрах хүрээ, бүрэлдэхүүн

1. Цаг уур, орчны шинжилгээний газрын сүлжээний тасалдал 2026 оны 04 дүгээр сарын 13-аас эхлэн 4-5 давхарт сүлжээ тасарсан тухай;

2. Урьдчилан мэдээлэх газрын үйлчилгээнд ашигладаг НЦУТ-ийн харьяа Морин-Уулын радарын станцаас ирдэг үүлний бүтээгдэхүүн хардаг компьютер гацсан тухай;

3. Урьдчилан мэдээлэх газрын үйлчилгээнд ашигладаг 192.168.100.30-ийн сервер компьютер гацсан тухай;

4. Хиймэл дагуул (HIMAWARI)-ын мэдээний сервер компьютер гацсан, ЦУОШГ-ын 7 давхарын 701 тоот өрөөнд байрлуулсан тухай асуудлаар холбогдох албан хаагчдаас тайлбарыг авч Хяналт, дотоод аудитын хэлтсийн дарга Х.Оюунбилэг, ахлах мэргэжилтэн С.Наранчимэг нар 2026 оны 04 дүгээр сарын 21-ээс 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хооронд хянан шалгаж ажиллаа.

Гурав: Тогтоогдсон нөхцөл байдал

1. Цаг уур, орчны шинжилгээний газрын сүлжээ тасарсан асуудал

1.1. Урьдчилан мэдээлэх газрын дарга Л.Оюунжаргал “Өнгөрсөн 7 хоногт манай үйлчилгээнд ашигладаг Морин-Уулын радарын станцаас ирдэг бүтээгдэхүүн мэдээ ирэхгүй болсон. Бид нар учрыг тодруулаад компьютероо асаагаарай гэхэд манай энд сүлжээгүй болсон учир тэр дор нь нээж үзэж чадаагүй. Тэгээд 22 цагаас сүлжээ орсон” гэх агуулгатай.

1.2. Цаг уур, орчны шинжилгээний газрын 9 давхар байрны 4 давхарт сүлжээний тасалдал 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 15 цаг 01 минутаас эхэлсэн ба viber албан хаагчдын Namem all группэд Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхчимэг дараах хариуг өгсөн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Цаг уур, орчны шинжилгээний газрын сүлжээний доголдол гарсан огноо, засварласан албан хаагчид

№	Албан хаагчдын Namem all группэд сүлжээ тасарсан тухай бичсэн чат	Ч.Мөнхчимэгийн бичсэн чат	Сүлжээний үзлэг засвар хийсэн албан хаагч
1	2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 15 цаг 01 минут “4 давхарт интернэт сүлжээ тасарсан байна”	2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 15 цаг 30 минутад “Танай давхар тог тасраагүй биз дээ яагаад нэгээрээ байхгүй болов”	Ч.Мөнхчимэг
2	2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 09 цаг 16 минут	“4 давхарт switch асуудалтай байсан, интернэт зүгээр байгаа”	Ч.Мөнхчимэг

	“4 давхарт интернэт сүлжээ тасарсан байна”		
3	<p>2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 12 баг 29 минут “4 давхарт интернэт сүлжээ тасарсан байна. 5 давхарт минутад сүлжээ тасарсан тухай бичигдсэн байна” Орой 17 цаг 01 минутад сүлжээ 4, 5 давхарт тасарсан хэвээр байгааг албан хаагчид чатад бичсэн байна.</p>	<p>2026 оны 04 дүгээр сарын 17-ны 19 цаг 37 минут “Бүгдэд үдшийн мэндээ. Интернэт сүлжээ бүхэлдээ асуудал гараад байгаа байна шүү. Хүрээлэнгийн залуучууд ажиллаж байна одоо ч. Ерөнхий дээрээ асуудал гарсан инженерүүд нь шийдвэрлэхээр ажиллаж байгаа тул амралтын өдрүүдээр шийдвэрлэгдчих байхаа” 2026 оны 04 дүгээр сарын 17-ны 19 цаг 45 минут “Өнөөдөртөө янзалнаа. Тэгж удахгүй ш дээ. Агаар тэнгэр муудах үед бол бүр л шуурхай 24/7 байдаг даа. 4, 5 давхарт дур мэдэн сүлжээ юмаа залгаж салгасан хүн байгаа юу. Loop эргэсэн байна гэж байна шүү. Сүлжээ юманд заавал намайг дуудаж үйлчилгээ авч байгаарай гэхдээ одоогоор би байхгүй хүрээлэнгийн залуучуудад хэлээрэй, Дээр нь бас 1 хэлж анхааруулах зүйл байна. Манайхан дотоод сүлжээнд ftp сервер ашиглан файл юмаа хуваалцаж өгч авалцаарай. Гаднаас ер флаш юм хийж сүлжээг вирустүүлэх аюултай тул хийхгүй шүү. Оюунаа эгч линкийг тавьж тооллогын зургаа тавь гэсэн байна. Тэрийг шинэ албан хаагчид мэдэхгүй байгаа бол мэддэг хуучин хүмүүсээс асууж сураарай”</p> <p>2026 оны 04 дүгээр сарын 17-ны 20 цаг 05 минут Би Набад утасдаж хэлсэн зөвхөн манай доор байна гэсэн. Өнгөрсөн зун намайг ажилд орохоос өмнө В1 давхрын свич шатаад сольсон байсан тэрэнд л байх шиг байна. Тэгэхдээ 4.5 давхарт л өдөр сүлжээ салаад байсан нь loop эргэсэн байж болзошгүй гэж оношилсон байна. Буцаж хэлж мэдэгдье гэсэн</p> <p>2026 оны 04 дүгээр сарын 17-ны 21 цаг 58 минут “Цагийн өмнө интернэт сүлжээ хэвийн боллоо гэсэн шүү”</p>	О.Наранбадрах Б.Лхавга-Очир Г.Өнөболд
4	<p>2026 оны 04 дүгээр сарын 20-ны 07 цаг 16 минут “Өглөөний мэнд. Интернэт сүлжээ бн уу. 5 давхарт бхгүй бна” “Мэндээ, 4 давхарт байхгүй байна” “Амралтын өдрүүдэд бас байхгүй байсан. Өнөөдөр Ахметали ирнэ</p>	<p>2026 оны 04 дүгээр сарын 20-ны 07цаг 43 минут “4.5 davhariig salgasan bgan bna. Loop ergeseng ni olj bj zalgah gd. Naba ireed uzej bj zalgay gsn shu, Tur huleej bgarai”</p>	О.Наранбадрах Б.Лхавга-Очир Г.Өнөболд
5	<p>2026 оны 04 дүгээр сарын 21-ны 08 цаг 14 минут</p>		О.Наранбадрах Б.Лхавга-Очир Г.Өнөболд

	"Manai 5 davhart internet bna uu		
6	2026 оны 04 дүгээр сарын 22-ны 11 цаг 12 минут "4 давхар сүлжээ байна уу" "Bdagui ee" "6d bas bhgui bolchlo"	2026 оны 04 дүгээр сарын 22-ны 11 цаг 20 минут "Za bi hureelengiin Naba-s asuugaad ogii"	О.Наранбадрах Б.Лхавга-Очир Г.Өнөболд

ЦУОШГ-ын дотоод сүлжээ 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс эхэлж тасарч, 15-нд мөн адил тасарсан байхад ЦУОШГ-ын Улсын сүлжээний газрын Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхчимэг сүлжээ тасарсан гэмтлийг олж тогтоогоогүй байхдаа 04 дүгээр сарын 16-ны өдөр бүтэн өдөр цахимаар ажиллаад 17-ны өдрөөс эхлэн 28-ны дуустал хугацаанд ЦУОШГ-ын даргын 2026 оны 04 дүгээр сарын 07-ны А/72 дугаартай тушаалаар БНХАУ-д сургалтад хамрагдсан ба түүний эзгүй үед ажлыг хариуцах албан хаагчийг УСГ-ын дарга Д.Уламбаяр томилоогүй ба Ч.Мөнхчимэг эзгүй байх үеийн ажлаа агентлагийн өөр албан хаагчид үлдээгээгүй байна.

1.3. УЦУОСМХ-ийн Мэдээллийн технологи, сүлжээний хэлтсийн дарга О.Энхцэцэг "2026 оны 04 дүгээр сарын 17-ны 17 цагаас 22 цаг хүртэл ЦУОШГ-ын дотоод сүлжээнд гарсан гэмтлийг МТСХ-ийн инженер Б.Лхавга-Очир, Г.Өнөболд, О.Наранбадрах нар сүлжээг шалгаад гэмтэл 4, 5 давхарт байгааг мэдсэн ч ажлын бус цагаар өрөөнүүд цоожтой тул сүлжээг 4, 5 давхрын сүлжээг түр салгаж, УМГ-ын дотоод сүлжээ, интернэт сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажилласан. 18 цагаас хойш байсан учир газрын алба хаагчид тарсан байсан тул өрөө өрөөгөөр орж үзэж шалгах боломжгүй байсан ч 4-5 давхарт кабелийг шалгаж 100-ийн сүлжээг хэвийн болгосон. 4-5 давхарт аль нэгт нь богино холболт үүссэн байна. Хүрээлэнгийн дотоод сүлжээ болон тоног төхөөрөмж хэвийн ажиллаж байсан.

Ер нь бол ЦУОШГ-т компьютер, тоног төхөөрөмж, IT хариуцсан 2 ажилтан ажиллаж байхад яагаад бие биеэ орлоод ажилладаггүй юм бол сүлжээний асуудал үүсэхээр манай хэлтсийн ажилчдыг та нар хүрээд ир засаад өгөөч гэж байнга хэлдэг. Цалин авч ажиллаж байгаа нэг байгууллагын 2 хүн байхад яагаад манай ажилчдаар өөрсдийн ажлыг хийлгэх гээд байгааг ойлгохгүй байна. Эсвэл манай ажилчдад цалингийн хувь өгөх хэрэгтэй. Бидний ажил үүрэг өөр дор бүрнээ хэлтсийн төлөвлөгөөт ажлаа ажлын байрны тодорхойлолтын дагуу хийж амжуулаад завгүй байдаг.

2026 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр ЦУОШГ-ын дотоод сүлжээнд гарсан гэмтлийг дахин шалгаж, гэмтэл 4 давхарт Хүний нөөцийн мэргэжилтний өрөөнд Wireless төхөөрөмж, сүлжээний төхөөрөмжийг хооронд нь буруу холбож, богино холболт үүсгэснээр ЦУОШГ-ын дотоод сүлжээнд бүхэлдээ болон хэсэгчлэн интернэт сүлжээ тасарсныг олж тогтоон төхөөрөмжийг сүлжээнээс салгасан.

Би МТСХ-ийн дарга, инженерийн техникийн албан хаагчид нь 2026.04.17-2026.04.20 ний өдрүүдэд салхи шуургатай цаг агаар онц аюултай үзэгдэлтэй өдрүүдэд УМГ-ын сүлжээ, сервер дээр гарсан доголдлыг цаг алдалгүй шуурхай арга хэмжээ авч, шуурхай мэдээлэл үйлчилгээний бэлэн байдлын хангаж, ажил үүргээ хангалттай сайн биелүүлсэн гэж үзэж байна. Хэдийгээр манай хэлтсийн албан хаагчдын үндсэн цалин 1,436,000, бусад төсөл хөтөлбөрөөс цалин авдаггүй бөгөөд хүрээлэнгийн цалингийн төсөв хасагдахад хамгийн түрүүнд манай хэлтсийн цалин хасагддаг.

Цаашид цалингаа нэмэхгүйгээр инженер техникийн албан хаагчдын ачааллыг нэмэгдүүлэх нь ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах боломжгүй болно гэж үзэж байна" гэх агуулгатай.

1.4. УЦУОСМХ-ийн инженер О.Наранбадрах "2026 оны 04 дүгээр сарын 13-нд газрын байранд байхад сүлжээ тасалдсан тухайн үед яагаа юм бол гэж бодоод өнгөрсөн. УЦУОСМХ-ийн байранд байгууллагын төв сүлжээ байдаг эдгээр бол хэвийн ажиллаж

байгаа. 17-нд газрын сүлжээнд доголдол гарсан. Энэ нь өөр төрлийн төхөөрөмж залгасан, вирустээ зэргээс болж богино холболт үүсээд давхраараа сүлжээгүй болдог. 17-ны орой 18 цагаас эхлээд 4-5 давхрын сүлжээний кабель утаснуудыг хөөж үзээд 21.30-ийн үед хэвийн ажиллаж эхэлсэн. Алба хаагчид ажил тарсан болохоор ерөөнүүдээр явж яг ямар алдаа гарсныг олж тогтоогоогүй ч сүлжээг хэвийн болгосон. ЦУОШГ-ын Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан Х.Ахметалигийн хариуцдаг 192.168.100.30-ийн сервер компьютер УЦУОСМХ-ийн машин зааланд байдаг. Тэр компьютер нь хагас сайн өдөр гацсан тул амралтын өдөр тэр хүнийг дуудахгүйгээр техникчтэйгээ утсаар видео дуудлага хийж байгаад компьютерыг асааж унтрааж ажилд оруулсан. Угаасаа манай техникчид хийх боломжтой байхад амралтын өдөр тэр хүнийг дуудаж төвөг болох шаардлагагүй би утсаар зааж зөвлөөд ажилд оруулсан” гэх агуулгатай.

1.5. ЦУОШГ-ын Улсын сүлжээний газрын дарга Д.Уламбаяр “Энэ байрны дотоод сүлжээг Ч.Мөнхчимэг ер нь хариуцдаг. Ч.Мөнхчимэг бол кибер аюулгүй байдал хариуцсан Төрийн захиргааны ажилтан, Х.Ахметали бол код бичдэг өндөр ур чадвар бүхий ажилтан. Хэн хэнээ орлон ажиллах боломжгүй 2 өөр төрлийн ажил юм. Ер нь манай улсын сүлжээнд нэг нэгнээ орлон ажиллах боломж бараг л байхгүй хүн бүр тус тусын ажилтай. Дотоод сүлжээнд ажилладаг тоног төхөөрөмжүүдийг УЦУОСМХ-ийн машин зааланд 24 цагаар ажиллаж байгаа ээлжийн техникч хариуцдаг байх хэрэгтэй. Орон нутагт холбооны операторгүй болоод удаж байна. Энэ хүмүүс сүлжээний тоног төхөөрөмж хариуцан ажиллаж байх ёстой. Нэг сервер тогноос салахад мэдэхгүй байж болохгүй. Одоо бүх мэдээ тэдний оролцоогүй цахимаар дамжуулагдаж байна. Тухайн өдрийн сүлжээний асуудлыг мэдэхгүй учир Ч.Мөнхчимэгийг ирэхээр тайлбар бичиж өгье” гэх агуулгатай.

1.6. ЦУОШГ-ын Улсын сүлжээний газрын Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхчимэгээс 2026 оны 04 дүгээр сарын 29-нд тайлбар авахад “2026 оны 4 сарын 17-нд болсон сүлжээний тасалдлын хувьд миний бие Хятад улсад сургалтаар явж байсан тул УЦУОСМХ-ийн ерөнхий инженер О.Наранбадрахтай viber (Хятадад wechat л ажилладаг ба миний бие явахаасаа өмнө vnp ашиглахаар төлөвлөж суулгасан байсан тул ажилласан)-р холбогдож асуухад онош олох гээд ажиллаж байна. 4,5 давхрыг залгахлаар loor буюу сүлжээ битүүрч асуудал үүссэн тул тэр давхруудыг шалгаж байж холбоё гээд орхиод цаг агаарын муудалт болох гэж байгаа тул УМГ-ыг холбож үлдээлээ гэж хэлсэн. Тэр өдөр нь 5 дах өдөр байсан тул ирэх 1 өдөр нь тэр давхруудад сүлжээний холболтыг шалгаж ажиллуулна гэж байсан.

Намайг эзгүй үед орлон ажиллах хүн асуудалтай байгаа. Гадаад дотоод сүлжээний хувьд хүрээлэнгийн инженерүүд ерөнхий сүлжээг мэдэх тул хийж чадна. Харин систем серверүүдийн хувьд зарим системийн паспортыг Ахмед-Али мэдэх тул энгийн асуудлыг шийдэх байх мэргэжлийн түвшнийх болуул чадахгүй. Мэдээллийн технологийн мэргэжил 17 болж задардаг тул IT болгон бүгдийг чадна гэж бодож болохгүй шүү. Миний хувьд энэ байгууллагад 23 жил ажиллаж байна туршлагажсан тул бүгдийг хийж амжуулан ажилладаг болно.

2025 онд УЦУОСМХүрээлэнгээс ирсэн саналд сүүлийн 3 жилд шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангаагүй гэсэн санал нь ерөнхий сүлжээг зохицуулалт хийдэг зогсуурт байрлах тог баригчны батарей муудаж тог тасарч мотор луу шилжих 1-2 секундэд барихгүйгээс сүлжээ тасрах асуудал гарч байгаа. Хиймэл дагуулын хүлээн авах серверүүдийн тоног төхөөрөмжүүд хуучирч бас тог баригч ажиллахгүй болсноос гарсан шалтгаан байгаа. Мөн олон улсад мэдээлэл солилцооны сервер шаардлагатай байгааг цаг уурын автомат станцын 2023 онд сольсон серверийг өгч ашиглуулсан. Энэ нь улс орны эдийн засаг хүндэрч шаардлагатай тоног төхөөрөмжийг тендерээр авах эх үүсвэргүйгээс болоод байна” гэх агуулгатай тайлбарыг бичгээр өгсөн ба амаар өгсөн тайлбартаа би ТУ албан тушаалтан биш учраас үйлчилгээ үзүүлэхгүй, ТЗ төрийн захиргааны ажилтан гэв.

1.7. ЦУОШГ-ын Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан Х.Ахметали “Би газрын бараг бүх серверүүдийг хариуцдаг. Техникийн талыг хариуцах хүн байдаггүй. Шинэ сервер тавиад одоохондоо чи хариуцаад явж бай гэдэг. Дотоод сүлжээ тасалдсан үед би ээлжийн амралтаасаа 2 хоног авсан. Мөнхчимэгийн ажлыг

орлон ажиллахгүй ч хагас сайн өдөр Л.Оюунжаргал дарга ярихад би ирсэн. Хүрээлэнгийн инженерүүд сүлжээг ажилд оруулсан байсан”.

2. ЦУОШГ-ын Урьдчилан мэдээлэх газрын үйлчилгээнд ашигладаг радарын зураг харах компьютер гацсан тухай

2.1. Урьдчилан мэдээлэх газрын дарга Л.Оюунжаргал “Өнгөрсөн 7 хоногийн 4 дэх өдөр манай үйлчилгээнд ашиглагдаг Морин-Уулын радарын станцаас ирдэг бүтээгдэхүүн мэдээ ирэхгүй болсон. Бид нар учрыг тодруулахад Морин-Уулын радар түр зогсоогоод эргэж асаасан. Одоо зүгээр болсон унтраагаад цаг болоод эргэн асаагаарай гэхэд манай энд сүлжээгүй болсон учир тэр дор нь нээж үзэж чадаагүй. Тэгээд 22 цагаас сүлжээ ирсэн. Радарын мэдээ ирэхгүй нь хард дүүрсэнтэй холбоотой байсан. Энд бид нар өөрсдөө алдаагаа хайж зассан. Газрын хэмжээнд радар хариуцсан ажилтан ийм үед бидэнд тусалж өгөх хэрэгтэй байна. Тэр хүний ажлын байрны тодорхойлолтод юу гэж заасан юм. Бид анх авахдаа радар хариуцан гэж авсан санагдаж байна. Радарын мэдээ орж ирэхгүй бид нар сандран хайж байхад орж ирж туслаагүй, утсаар харин ярьсан. Радарын зураг хардаг компьютерын хард дүүрсэн байсан, бид өөрсдөө засаж янзалсан” гэх агуулгатай.

2.2. ЦУОШГ-ын Улсын сүлжээний газрын Хэмжих хэрэгсэл, хэмжил зүй, радарын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Баттүшиг “Морин-Уул радарын станцад ямар нэг доголдол үүсээгүй байсан. Радарын мэдээ яаж харах, ашиглах заавар, зөвлөмж байгаа 27 жил энэ байдлаар ажилласан. Радарын мэдээ болохгүй байна гэхээр 7 давхарт орж харахад 15-аас хойш нээж хараагүй компьютер нь гацсан байсан. Радарын инженерүүдээс асуугаарай тэд нар яаж ажиллах талаар тайлбар өгнө гэсэн боловч над руу дахин утсаар асуухаар нь компьютероо бүрэн унтраагаад асааж үзээ гэж зөвлөгөө өгсөн. Тэгээд ажилд орсон. Урьдчилан мэдээлэх газрын дарга хувь хүн над руу тэгж хандаж болохгүй би ажлын хариуцлага алдаагүй” гэх агуулгатай.

ЦУОШГ-ын Улсын сүлжээний газрын Хэмжих хэрэгсэл, хэмжил зүй, радарын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Баттүшиг ажлын байрны тодорхойлолтод “Суурин болон явуулын радарын сүлжээ байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тасралтгүй ажиллагааг хангах, хяналт тавих” гэсэн зорилттой.

2026 оны 04 дүгээр сарын 17-нд Нислэгийн цаг уурын төвийн харьяа Морин-Уул радарын станц ажиллаж Морин-Уул дээрх ажлын компьютер болон Нислэгийн цаг уурын төвд мэдээ хэвийн харагдаж байсан.

ЦУОШГ-ын Урьдчилан мэдээлэх газрын үйлчилгээнд ашигладаг радарын мэдээ хүлээн авах компьютер гацаж үүлний ажиглалтын мэдээг харах боломжгүй болсон. Тухайн компьютерын хард дүүрсэн байсныг урьдчилан мэдээлэхийн газрын дарга, инженерүүд өөрсдөө олж тогтоон зассан байна.

2.3. Нислэгийн цаг уурын төвийн харьяа Морин-Уул радарын станцын 71283235 дугаартай утас руу 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр холбогдоход инженер Наранбаатар ээлжтэй байв. “Би 2026 оны 04 дүгээр сарын 15-нд ээлжид гарсан. Манай радар өнгөрсөн хугацаанд ажиллахгүй зогсоогүй. Ээлж хүлээлцэх дэвтэрт ямар нэг тэмдэглэл хийгээгүй байна” гэх агуулгатай.

2.4. Нислэгийн цаг уурын төвийн харьяа Морин-Уул радарын станцын инженер Энхбаяртай 71283235 дугаартай утсаар холбогдоход “2026 оны 04 дүгээр сарын 17-нд манай станц хэвийн ажилласан. Урьдчилан мэдээлэх газрын компьютерт мэдээ очихгүй байна гэж над руу утсаар ярьсан. Энэ нь манай 2 компьютерын цагийн зөрөөнөөс болсон байх компьютероо унтрааж дахин ачаалах хэрэгтэй гэж хэлсэн. Тэгээд зүгээр болсон уу дахин над руу залгаагүй. Манай компьютер 2008 онд ажиллаж эхэлсэн цаг нь батарейгаар цэнэглэгддэг тул цагийн зөрөө үүсээд байдаг болсон. Бид нар 2025 оны 11 сард 20-иод минутын зөрөө гарахад зассан одоо дахиад зөрөө гарч байна. Манай радар өнгөрсөн хугацаанд ажиллахгүй зогсоогүй. Харин 2026 оны 04 дүгээр сарын 25-нд Морин-Уул руу агаараар ирсэн шилэн кабель нь салхинд савласаар байгаад тасарч мэдээ дамжигдахгүй сүлжээнд саатал гарсан. Манайх хоорондоо гар утсаараа мэдээгээ илгээж байна. Одоо түр

холболт хийсэн орж гараад л байна. Нисэхийн албанаас хүмүүс ирсэн засаж байна” гэх агуулгатай.

Нислэгийн цаг уурын төвийн харьяа Морин-Уул радарын станц 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өглөөний 9 цаг 45 минутаас эхлэн шилэн кабель тасарч сүлжээгүй болсон. 25-26-нд буюу амралтын өдрүүдээр сүлжээгүй тул нислэгийн урьдчилан мэдээлэхийн инженерт утсаараа радарын үүлний зургийг авч явуулж байсан. 27-нд Иргэний нисэхийн холбооны ажилчид ирж шилэн кабелийг засварласан байна.

3. ЦУОШГ-ын Урьдчилан мэдээлэх газрын 192.168.100.30-ийн сервер компьютер гацсан тухай

3.1. Урьдчилан мэдээлэх газрын дарга Л.Оюунжаргал “2026 оны 04 дүгээр сарын 18-ны хагас сайн өдөр УЦУОСМХ-ийн машин зааланд байгаа 100.30 буюу урьдчилсан мэдээний зураг, материал хардаг сервер компьютер мэдээ харж болохгүй болоод асааж унтраалгасан. Уул нь энэ тоног төхөөрөмжийг тэнд 24 цагаар ажиллаж байгаа ээлжийн техникч нарыг асааж унтрааж өгч болмоор санагдах юм. Инженерт нь хэлж байж асааж унтраалгаж ажилд оруулсан. Цаашдаа хэнд хариуцах талаар тодорхой болгох хэрэгтэй байна. Доторх мэдээг Х.Ахметали хариуцан боловсруулалт, программ хангамжийн хэвийн ажиллагааг хариуцдаг”.

3.2. ЦУОШГ-ын Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан Х.Ахметали “Би их олон серверүүдийг хариуцдаг түүний нэг нь 192.168.100.30-ийн доторх мэдээлэл программ хангамжийн аюулгүй байдал хэвийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Техникийн талыг хариуцах хүн байдаггүй. Газрын бараг бүх сервер буюу архив, 100.43 гээд шинэ сервер, агаарын бохирдлын гэх зэргийг хариуцдаг. За одоохондоо юу ч гэсэн хариуцаад явж бай л гэдэг. 192.168.100.30 серверт тог баригч UPS байдаггүй. Машин зааланд байгаа тог баригч UPS-д Хүрээлэнгийн тоон прогнозын сервер холбоотой байдаг. Энэ ч бас тог тасрах үед сайн барьж чадахгүй бараг бүгд унтардаг. Миний хариуцаж байгаа weather.gov.mn-ийн сервер л тог баригч UPS-тай байна. Амралтын хагас сайн өдөр Л.Оюунжаргал дарга ярихад би ирсэн. Хүрээлэнгийн инженерүүд 192.168.100.30-ийг ажилд оруулсан байсан. Урьдчилан мэдээлэхийн мэдээ бичдэг программын ажиллагаанд доголдол гарсан байсныг засварлаад явсан” гэх агуулгатай.

3.3. УЦУОСМХ-ийн Мэдээллийн технологи, сүлжээний хэлтсийн дарга О.Энхцэцэг “Манай машин зааланд олон төрлийн сервер компьютер байрлуулдаг. Тэнд 24 цагаас ээлжийн техникч сууж ажилладаг тул эрүүл мэндэд сөрөг нөлөөлтэй, дуу чимээ ихтэй ажлын ачаалал нэмдэг. Ээлжийн техникчийг инженерийн зөвшөөрөлгүй сервер компьютерыг асааж унтрааж болохгүй гэсэн чиглэл өгдөг.

192.168.100.30-ийн сервер компьютерыг анхнаас нь машин зааланд тавихад бид нар хариуцахгүй гэдгээ Л.Оюунжаргал даргад хэлж байсан. 2026 оны 04 дүгээр сарын 18-ны хагас сайн өдөр ажиллахгүй болсон тул манай инженер О.Наранбадрах утсаар техникч нартаа зааж өгч асааж унтрааж хэвийн болгосон.

Би МТСХ-ийн дарга, инженерийн техникийн албан хаагчид нь 2026.04.17-2026.04.20 ний өдрүүдэд салхи шуургатай цаг агаар онц аюултай үзэгдэлтэй өдрүүдэд УМГ-ын сүлжээ, сервер дээр гарсан доголдлыг цаг алдалгүй шуурхай арга хэмжээ авч, шуурхай мэдээлэл үйлчилгээний бэлэн байдлын хангаж, ажил үүргээ хангалттай сайн биелүүлсэн гэж үзэж байна” гэх агуулгатай.

3.4. УЦУОСМХ-ийн инженер О.Наранбадрах “ЦУОШГ-ын Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан Х.Ахметалигийн хариуцдаг 192.168.100.30-ийн сервер компьютер УЦУОСМХ-ийн машин зааланд байдаг. Тэр компьютер нь хагас сайн өдөр гацсан тул амралтын өдөр тэр хүнийг дуудахгүйгээр техникчтэйгээ утсаар видео дуудлага хийж байгаад компьютерыг асааж унтрааж ажилд оруулсан. Угаасаа манай техникчид хийх боломжтой байхад амралтын өдөр тэр хүнийг дуудаж төвөг болох шаардлагагүй би утсаар зааж зөвлөөд ажилд оруулсан” гэх агуулгатай

4. ЦУОШГ-ын Урьдчилан мэдээлэх газрын үйлчилгээнд ашигладаг хиймэл дагуулын сервер компьютер гацсан тухай

4.1. Урьдчилан мэдээлэх газрын дарга Л.Оюунжаргал “Мөн хиймэл дагуулын сервер компьютерыг тог баригчгүй гээд манайд тавьсан. Хүрээлэн тэр олон төслөөс ганц нэг UPS авахад яагаад болохгүй гэж. Хиймэл дагуулын сервер компьютерын мэдээг харахад 2026 оны 17-ны 22 цагаас 18-ны 00 цаг хүртэл тасралт үүссэн. О.Оюунчимэгт хэлээд сервер компьютерыг манай өрөөнд тавьсан байна” гэх агуулгатай.

4.2. УЦУОСМХ-ийн инженер О.Анхбаяр “2026 оны өвөл буюу цагаан сарын үеэр Урьдчилан мэдээлэх газрын ажлын байранд хиймэл дагуулын сервер компьютерыг оруулж тавьсан. Ахлах мэргэжилтэн О.Оюунчимэг болон тухайн өдрийн ээлжийн инженер нарт хэлж тог баригчид холбож байршуулсан. Олон өдрийн амралттай үеэр цахилган тасарвал доор машин зааланд тог баригчгүй тул мэдээ дамжуулалт тасрах магадлалтай тул ингэж тог баригчид холбож өгсөн. Үүнийг хариуцдаг гэж би анх нэмэгдэл авч байсан ч одоо бол нэмэгдэл авдаггүй. Уул нь шууд мэдээг ашиглаж байгаа газраа сервер компьютер байвал зөв гэж би бодсон” гэх агуулгатай.

2026 оны цагаан сарын өмнө хиймэл дагуулын сервер компьютерыг ЦУОШГ-ын УМГ-ын 7 давхарт тог баригчид холбон ахлах мэргэжилтэн болон ээлжийн инженер нарт хэлээд асааж унтраах үед ашиглах зааврыг бичиж наасан. Урьдчилан мэдээлэх газрын дарга Л.Оюунжаргал тухайн үед эзгүй байгаад мэдээгүй, 2026 оны 04 дүгээр сарын 17-нд хиймэл дагуулын мэдээ орж ирэхгүй болоход мэдсэн. 2026 оны 17-ны 22 цагаас 18-ны 00 цаг хүртэл тасралт үүссэн байна.

О.Анхбаяр 2024-2025 оны хооронд “MODIS хиймэл дагуулын хүлээн авах систем, DataCube системд хиймэл дагуулын хүлээн авсан мэдээг хэвийн дамжуулах ажиллагааг хангах” ажлыг хавсран гүйцэтгэж цалингийн 20-25%, 2026 оны 01 дүгээр сарын байдлаар “DataCube системд хиймэл дагуулын хүлээн авсан мэдээг хэвийн дамжуулах ажиллагааг хангах” ажлыг хавсран гүйцэтгэж цалингийн 15% авдаг байна.

Дөрөв: Дүгнэлт

1. ЦУОШГ-ын дотоод сүлжээ 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс эхэлж тасарч, 15-нд мөн адил тасарсан байхад ЦУОШГ-ын Улсын сүлжээний газрын Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхчимэг сүлжээ тасарсан гэмтлийг олж тогтоогоогүй байж 04 дүгээр сарын 16-ны өдөр бүтэн өдөр цахимаар ажиллаж, албан тушаалын тодорхойлолтод заасан дотоод цахим сүлжээ, сүлжээний тоног төхөөрөмжийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаагүй байна.

2. ЦУОШГ-ын дотоод сүлжээ 2026 оны 04 дүгээр сарын 13-22-ны хооронд үе үе тасалдаж байсан гэмтлийг УЦУОСМХ-ийн Мэдээллийн технологи, сүлжээний хэлтсийн инженер О.Наранбадрах, Б.Лхавга-Очир, Г.Өнөболд нар олж, 4 давхрын 401 тоот өрөөнд Wireless төхөөрөмж, сүлжээний төхөөрөмжийг хооронд нь буруу холбож, богино холболт үүсгэснээр дотоод сүлжээ бүхэлдээ болон хэсэгчлэн тасарсныг олж тогтоон төхөөрөмжийг сүлжээнээс салгаж сүлжээг хэвийн болгосон байна.

3. Улсын сүлжээний газрын дарга Д.Уламбаяр Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхчимэгийг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 28-ны дуустал хугацаанд гадаад томилолттой үеийн 10 хоног эзгүй хугацаанд түүний ажлыг орлон гүйцэтгэх албан хаагчийг дотоод зохион байгуулалтаар шийдвэрлээгүй байна.

4. Урьдчилан мэдээлэх газрын 192.168.100.30-ийн сервер компьютер УЦУОСМХ-ийн машин зааланд байдаг бөгөөд 2026 оны 04 дүгээр сарын 18-ны хагас сайн өдөр гацсан тул УЦУОСМХ-ийн инженер О.Наранбадрах ээлжийн техникчтэй утсаар ярьж зааварчилга өгч ажилд оруулсан байна.

5. ЦУОШГ-ын хэмжээнд нийт 19 сервер үүнээс тог баригчгүй 7 сервер, давхар холбосон буюу эрсдэлтэй 7 сервер байдаг бөгөөд Улсын сүлжээний газрын Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхчимэг 6 сервер, Технологи,

инновацын хэлтсийн Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан Х.Ахметали 8 сервер, Архив, мэдээллийн сангийн хэлтэс 1 сервер хариуцан ажиллаж байна.

6. Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхчимэгийн албан тушаалын тодорхойлолтод заасан “Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын мэдээ, мэдээллийг солилцох гадаад болон дотоод цахим сүлжээ, сүлжээний тоног төхөөрөмжийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж, хяналт тавих” чиг үүргийн дагуу ЦУОШГ-т бүртгэлтэй сервер, сүлжээг бүрэн хариуцаж ажилладаггүй.

7. Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан Х.Ахметали, Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхчимэг нар эзгүй үед хоорондоо ажлын чиг үүргээ орлон ажилладаггүй.

8. Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Мөнхчимэг нь өөрийгөө ТЗ буюу захиргааны ажилтан учраас ТҮ үйлчилгээний ажилтны засвар үйлчилгээний ажлыг хариуцах албагүй, мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан Х.Ахметалиг зарим системийн паспортыг мэддэг энгийн асуудлыг мэднэ, мэргэжлийн түвшинд биш гэв.

9. Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаал Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын мэдээ, мэдээллийг солилцох гадаад болон дотоод цахим сүлжээ, сүлжээний тоног төхөөрөмжийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж, хяналт тавих байнгын тасралтгүй шуурхай байх тул цаашид уг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг цахимаар ажиллуулах нь байгууллагад урьдчилан мэдэх боломжгүй эрсдэл үүсэх нөхцөлтэй байна.

10. Нислэгийн цаг уурын төвийн харьяа Морин-Уул радарын станц 2026 оны 04 дүгээр сарын 17-нд хэвийн ажилласан ба УМГ-ын 701 тоот өрөөнд байрлах шуурхай үйлчилгээнд ашигладаг радарын компьютерт мэдээ ирэхгүй байсан нь хард диск дүүрсэн шалтгаанаас болж үүсжээ.

11. Хэмжих хэрэгсэл, хэмжил зүй, радарын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Баттүшиг нь радарын мэдээг ашиглах, үйлчлэх чиглэлээр заавар зөвлөмж өгөх үүрэгтэй боловч УМГ-ын 701 тоот өрөөнд байрладаг радарын мэдээ харах компьютерын хард диск дүүрсэн асуудлыг хянадаггүй байна.

12. Нислэгийн цаг уурын төвийн харьяа Морин-Уул радарын станцын ажиллагаа 2026 оны 04 дүгээр сарын 25-ны 09 цаг 45 минутаас эхлэн шилэн кабель салхинд тасарч сүлжээгүй болсныг Иргэний нисэхийн холбооны ажилчид шилэн кабелийг засварлаж 04 дүгээр сарын 27-нд хэвийн ажиллагаанд холбосон байна.

13. Урьдчилан мэдээлэх газрын үйлчилгээнд ашигладаг хиймэл дагуул (Himawari)-ын мэдээний сервер компьютерыг УЦУОСМХ-ийн инженер О.Анхбаяр хариуцан ажиллаж байгаад 2026 оны цагаан сарын өмнө ЦУОШГ-ын УМГ-ын 7 давхарт тог баригчид холбож үлдээхдээ эд хөрөнгө хүлээлгэн өгсөн, авсан акт үйлдээгүй.

14. Урьдчилан мэдээлэх газрын үйлчилгээнд ашигладаг хиймэл дагуул (Himawari)-ын сервер 2026 оны 04 дүгээр сарын 17-ны 22 цагаас 18-ны 00 цаг хүртэл тасралт үүсэх үед Урьдчилан мэдээлэх газрын дарга Л.Оюунжаргал 701 тоот өрөөнд уг хиймэл дагуул (Himawari)-ын мэдээний сервер компьютер байгааг мэдсэн байна.

15. Хяналт, дотоод аудитын хэлтсийн 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хяналт шалгалтын танилцуулгад Улсын сүлжээний газар, Урьдчилан мэдээлэх газар, архивын хэлтэс, Захиргааны хэлтэст “Цаг уурын 137 станцын FM 71-XII мэдээний (192.168.100.115 УЦУОСМХ-ийн сервер), 180 харуулын мэдээг АК-01 өдөр тутмын мэдээнээс (192.168.100.30 Урьдчилан мэдээлэх газрын сервер) болон салбарын хэмжээний серверт хадгалагддаг мэдээ баримтыг, хадгалах, дамжуулах, ашиглах, бүртгэх аргачилсан заавар, журмыг боловсруулж батлуулах” өгсөн саналыг хэрэгжүүлээгүй.

Тав: Зөвлөмж
УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ ГАЗАРТ

Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын мэдээ, мэдээллийг солилцох гадаад болон дотоод цахим сүлжээ, сүлжээний тоног төхөөрөмжийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж, хяналт тавих чиг үүргийн бүрэн хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, дүгнэлтийн дагуу богино хугацаанд үр дүнд хүрэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

1. Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн танилцуулж, цаашид эзгүй үед түүнийг орлон ажиллах албан хаагчийг томилж, ажлын байрны хийдэл үүсгэж, байгууллагад үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

2. ЦУОШГ-т бүртгэлтэй нийт 19 серверийг хариуцан ажиллах албан тушаалтныг тушаалаар албажуулах;

3. ЦУОШГ-ын албан хаагчдад сервер компьютер, мэдээллийн систем, зохистой ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тогтмол заавар, зөвлөмжөөр хангах сургалт хийх;

4. Компьютерын хэвийн ажиллагаанд нөлөөлөх (шаардлагагүй файл хуримтлуулах, баталгаагүй программ суулгах зэрэг) эрсдэлийг бууруулах зорилгоор хэрэглэгчийн хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах;

5. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хэсэг байгуулж, салбарын хэмжээнд болон УЦУОСМХ-ийн машин зааланд байх бүх төрөл серверийг бүртгэж (нэр, IP хаяг, байршил, ашиглагдаж буй үйлчилгээ, OS, хувилбар) сервер, компьютер тус бүрээр эзэнжүүлж, байгууллага, нэгж албан хаагч тус бүрийн хариуцах чиг үүргийг оновчтой тогтоож, хяналт-удирдлагыг хэрэгжүүлэх аргачилсан заавар, журмыг боловсруулж 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлуулах.

ЗАХИРГААНЫ ХЭЛТЭСТ

Байгууллагын хэвийн, тасралтгүй, цахим сүлжээ, харилцаа холбооны тогтвортой байдлыг бүрэн хангаж салбарын онцлог, албан хаагчийн хариуцсан ажил гүйцэтгэх чиг үүрэг, ажил мэргэжлийн онцлогийг харгалзан зайнаас, цахимаар ажиллах боломжгүй ажлын байрны жагсаалтыг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор баталж мөрдүүлэх.

Хавсралт ... хуудастай

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА

Э.БАТТУЛГА

2026 оны 05 дугаар сарын 11

ХЯНАСАН:
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ОЮУНБИЛЭГ

2026 оны 05 дугаар сарын 06

БОЛОВСРУУЛСАН:
ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С.НАРАНЧИМЭГ

2026 оны 05 дугаар сарын 06

Тав: Санал

**УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР, УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ ГАЗАР, АРХИВЫН ХЭЛТЭС,
ЗАХИРГААНЫ ХЭЛТЭСТ**

Цаг уурын 137 станцын FM 71-XII мэдээний (192.168.100.115 УЦУОСМХ-ийн сервер), 180 харуулын мэдээг АК-01 өдөр тутмын мэдээнээс (192.168.100.30 Урьдчилан мэдээлэх газрын сервер) болон салбарын хэмжээний серверт хадгалагддаг мэдээ баримтыг, хадгалах, дамжуулах, ашиглах, бүртгэх аргачилсан заавар, журмыг боловсруулж батлуулах.

УС ЦАГ УУР, ОРЧНЫ СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНД

1. УЦУОСМХ-ийн захирлын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн "Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай" А/70 дугаар тушаалаар батлагдсан дотоод журмын 6.1.5-д Хүрээлэнд хэрэгжүүлж буй гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, гэрээт ажлын зохицуулагч болон гүйцэтгэгчид олгох нэмэгдэл хөлсийг ажил үүргийн оролцоог үндэслэн тогтоож олгох заалтыг мөрдөж ажиллах;

2. УЦУОСМХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Гомболүүдэв, ЗТСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Баясгалан нар 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 2025/15 дугаартай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний хэрэгжилтийг дүгнэж, Г.Баясгалын гүйцэтгэсэн ажилд тохирсон гэрээт ажлын хөлсийг олгох.

ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭСТ

УЦУОСМХ-д хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, албан хаагчдын цалин, хөлсөөр ажилласан гэрээт ажлын төлбөр зэрэг асуудалд санхүүгийн хяналт шалгалт хийх удирдамж батлуулж, тайланг 2026 оны 02 дугаар улиралд багтаж танилцуулах.

Хавсралт ... хуудастай.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА

2026 оны 01 дүгээр сарын ...



ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

2026 оны 01 дүгээр сарын 21

Х.ОЮУНБИЛЭГ

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

2026 оны 01 дүгээр сарын 21

Б.БААСАНСҮРЭН